

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАНГ
БЭЛТГЭСЭН:Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Аудитор /гэрээт ажилтан/

Х.Баттулга

2018 оны 5 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70342716
дугаарын утас, 70342580
дугаарын факсаар
харилцана уу.

Цахим хаяг:
Bulgan@audit.gov.mn

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй.....2-3

Бүлэг 1: Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим, зохион байгуулалт, тавигдах шаардлагууд хэрэгжсэн үү?

1.1.Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим, зохион байгуулалт 3-4

1.2. Хяналт шалгалт 4

Бүлэг 2: Санхүүжилтийг хэрхэн бүрдүүлсэн, үр ашигтай зарцуулсан, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан эсэх:

2.1.Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалт 4-6

2.2.Хувь хүний орлогын албан татвар төлдөггүй байна. 6

Бүлэг 3: Хүүхдийн “Жаргалант” зуслангийн үйл ажиллагаа.

3.1.Үндсэн хөрөнгөд харуул хамгаалалт байхгүй байна.

Дүгнэлт, зөвлөвж.....6-9

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2018.05.24

Булган

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Монгол улсын ерөнхий аудиторын тушаал, аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу бүрэн эрхийн хүрээнд аудит хийлээ.

2. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь Булган аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд харах үйлчилгээ, Жаргалант зуслангийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч, холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ

Аудитыг дараах үндсэн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим, тавигдах шаардлага, зохион байгуулалт, санхүүжилтийг хэрхэн бүрдүүлсэн, үр ашигтай зарцуулсан эсэх
- Хүүхдийн Жаргалант зуслангийн бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашиг
- Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласан эсэх
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтайгаар зарцуулсан эсэх
- Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал
- Хууль тогтоомжийг баримталсан эсэх

3. Аудитын хамрах хүрээ:

Булган аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд харах үйлчилгээ, Жаргалант зуслангийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан мэдээ, холбогдох судалгаа баримтууд хамрагдлаа.

4. Аудитын арга зүй:

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5.Шалгуур үзүүлэлт:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Холбогдох бусад хууль, тогтоомж

Үндсэн мэдээлэл:

Булган аймгийн хэмжээнд 2017 онд Булган, Хишиг-Өндөр, Могод, Баяннур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Тэшиг, Хутаг-Өндөр сумдад 41 хүүхэд харагч, 19 байранд 181 хүүхэдтэй үйлчилгээ явуулснаас оны эцэст 37 хүүхэд харагч, 17 байр үйл ажиллагаа явуулсан байна.

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

**Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим,
зохион байгуулалт тавигдах шаардлагууд
хэрэгжсэн үү?**

Бүлэг I

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13.2-т заасны дагуу сумын Засаг даргаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл аваагүй үйл ажиллагаа явуулсан байна.

1.Хүүхэд харах үйлчилгээнд баримтлах зарчим, зохион байгуулалт:**1.1.Сумын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаагүй байна.**

Хүүхэд харагч нар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй хүүхэд харах үйлчилгээний сургалт нд сууж хүүхэд харах чадамжийн гэрчилгээ авч сумын Засаг даргаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч ажиллаж байна.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 5, 6 дугаар зүйл, Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журмын дагуу нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо 5-с ихгүй, төрийн өмчийн цэцэрлэгт давхар хамрагдаагүй байх шаардлагуудыг ханган үйлчилгээг үзүүлж байна.

Хүүхдийн хоолыг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалаар баталсан 1-3, 4-6 насны хүүхдийн хоногийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг нормативын дагуу өдөр бүр өгч байна.

Сумын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаагүй нь хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмын 1.3-т “хүүхэд харагч нь сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасныг зөрчжээ.

Нийт хүүхэд харагч нар хүүхдийн ирцийн бүртгэлийг хөтөлдөг боловч Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журмын 4.8.3-т “эцэг эх, асран хамгаалагч, нь хүүхдийн ирцийн бүртгэлийн дэвтэрт өглөө хүүхдээ хүлээлгэн өгөх, орой хүлээн авах бүрдээ гарын үсэг заавал зурж баталгаажуулна” гэж заасны дагуу эцэг эх, асран хамгаалагч нараар гарын үсэг зуруулан баталгаажуулдаггүй байна.

1.2.1. Хяналт шалгалт:

Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журмын 7-д “Төрийн байгууллагын зүгээс Мэргэжлийн хяналтын байгууллага, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, Баг хорооны Засаг дарга нь хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг хангаж байгаа эсэхэд хамтран хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн ГБХЗХГ-аас хяналт тавьж ажилласан, Мэргэжил хяналтын газраас ирж ажилласан гэх боловч ямар хяналт, дүгнэлт гаргасан нь тодорхойгүй, багийн засаг дарга нараас хийсэн хяналт байхгүй байна..

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

Санхүүжилтийг хэрхэн бүрдүүлсэн, үр ашигтай
зарцуулсан, санхүүгийн тайланд үнэн зөв
түсгасан эсэх

Бүлэг II

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 12.1.2-т заасны дагуу санхүүгийн бүртгэл, тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж ажиллаагүй байна.

2.Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалт:

2.1.Хувь хүний орлогын албан татвар төлдөггүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 2-ний өдрийн 242 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг шинэчлэн баталсны дагуу 2017 онд 213798.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 212525.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүүхэд харагч бүрийн харилцагч

банкны хувийн харилцах дансанд олгож 1273.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 212525.0 мянган төгрөгийн санхүүжилт ирснээс хүүхдийн хоолонд 59052.8, хувьсах зардалд 41925.4, цалинд 111547.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 12.1.2-т заасны дагуу санхүүгийн бүртгэл, тайланг анхан шатны баримтын бүрдэл дутуу, холбогдох хууль тогтоомжийн бүртгэл тайлан хийж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.3 "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 18.1.7-д "хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12.1.1 "эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлогоос татвар төлнө" гэж заасны дагуу авч буй цалингаас хувь хүний орлогын албан татвар төлөөгүйд зөвлөмж хүргүүлээ. Хүүхэд харагч бүрийг хүснэгтээр харуулбал:

№	ХХ-н нэрс	ХХҮ эрхэлж буй сумын нэр	Олгосон санхүүжилт	хоол	Зарцуулалт			Ногдох татвар
					зардал	цалин	НИЙТ	
1	П.Агиймаа	Булган сум	5,090,631	1,479,113	1,476,455	2,135,063	5,090,631	213,506
2	Э.Алтантуяа		4,979,783	1,464,024	1,111,637	2,404,122	4,979,783	240,412
3	Б.Мягмар		5,292,795	1,564,736	1,150,000	2,578,059	5,292,795	257,806
4	н.Энхчимэг	Булган сум	2,845,600	868,714	750,000	1,226,886	2,845,600	122,689
5	Г.Оюун-эрдэнэ		2,447,195	696,022	400,000	1,351,173	2,447,195	135,117
6	Н.Ганчимэг		5,292,795	1,640,036	1,273,366	2,379,393	5,292,795	237,939
7	М.Баярцогт	Булган сум	5,292,795	1,640,036	1,273,366	2,379,393	5,292,795	237,939
8	Б.Батцэцэг		5,292,795	1,563,228	1,401,471	2,328,096	5,292,795	232,810
9	Б.Жавзандулам		5,292,795	1,764,285	1,260,092	2,268,418	5,292,795	226,842
10	Э.Сүх-Эрдэнэ	Булган сум	5,700,008	1,532,240	713,339	3,454,429	5,700,008	345,443
11	А.Ялалт		5,130,131	1,532,240	713,339	2,884,552	5,130,131	288,455
12	С.Гантөмөр		5,016,289	1,911,089	56,601	3,048,599	5,016,289	304,860
13	Д.Тамир	Хутаг-Өндөр	5,440,479	1,834,085	289,172	3,317,222	5,440,479	331,722
14	Б.Отгончимэг	Булган сум	5,292,795	1,533,418	490,760	3,268,617	5,292,795	326,862
15	н.Үүрийн туяа		2,845,600	851,200	490,760	1,503,640	2,845,600	150,364
16	Д.Ганчимэг		2,447,195	682,218	-	1,764,977	2,447,195	176,498
17	Л.Одончимэг		2,149,085	682,218	-	1,466,867	2,149,085	146,687
	Булган		75,848,766	23,238,902	12,850,358	39,759,506	75,848,766	3,975,951
18	П.Нарангарав	Тэшиг	6,143,085	1,519,762	1,398,136	3,225,187	6,143,085	322,519
19	Ц.Алтансүвд		6,143,085	1,519,762	1,398,136	3,225,187	6,143,085	322,519
20	Э.Нарангэрэл		2,470,845	655,171	455,774	1,359,900	2,470,845	135,990
21	Э.Ариунтуяа	Тэшиг	6,143,085	1,554,041	1,223,264	3,365,780	6,143,085	336,578
22	Н.Нарантуяа		6,143,085	1,554,041	1,223,264	3,365,780	6,143,085	336,578

23	Б.Отгон		6,143,085	1,554,041	1,223,264	3,365,780	6,143,085	336,578
24	Э.Нармандах		6,143,085	1,620,133	961,022	3,561,930	6,143,085	356,193
25	Б.Мөнгөнзагас	Тэшиг	6,049,815	1,620,133	961,022	3,468,660	6,049,815	346,866
26	Ч.Энхсүвд		6,074,687	1,620,133	935,022	3,519,532	6,074,687	351,953
	Тэшиг		51,453,857	13,217,217	9,778,904	28,457,736	51,453,857	2,845,774
27	Ж.Дэлгэрцэцэг	Хишиг-Өндөр	5,828,265	1,474,318	1,152,400	3,201,547	5,828,265	320,155
	Хишиг-Өндөр		5,828,265	1,474,318	1,152,400	3,201,547	5,828,265	320,155
28	Ч.Даш-Өлзий	Дашинчилэн	6,143,085	1,579,585	1,717,040	2,846,460	6,143,085	284,646
29	Н.Бямбасүрэн		6,143,085	1,573,935	1,548,160	3,020,990	6,143,085	302,099
	Дашинчилэн		12,286,170	3,153,520	3,265,200	5,867,450	12,286,170	586,745
30	Д.Эрдэнэтуяа	Могод	6,143,085	1,874,535	1,124,280	3,144,270	6,143,085	314,427
	Могод		6,143,085	1,874,535	1,124,280	3,144,270	6,143,085	314,427
31	Д.Отгонжаргал		5,483,965	1,369,183	1,271,225	2,843,557	5,483,965	284,356
32	О.Батцэцэг	Рашаант	6,143,085	1,558,916	1,339,659	3,244,510	6,143,085	324,451
33	Ц.Баянзул		6,143,085	1,558,916	1,339,659	3,244,510	6,143,085	324,451
34	Б.Цэвэрэгзэн		3,295,600	987,440	75,752	2,232,408	3,295,600	223,241
	Рашаант		21,065,735	5,474,455	4,026,295	11,564,985	21,065,735	1,156,499
35	Д.Дашдэлгэр		6,093,341	1,640,329	896,096	3,556,916	6,093,341	355,692
36	Х.Цэрэннадмид	Баяннуур	6,068,469	1,640,329	856,296	3,571,844	6,068,469	357,184
37	Н.Алтанзагас		6,049,815	1,640,329	891,096	3,518,390	6,049,815	351,839
38	н.Хишигдүүрэн		3,258,292	1,066,890	447,367	1,744,035	3,258,292	174,404
	Баяннуур		21,469,917	5,987,877	3,090,855	12,391,185	21,469,917	1,239,119
39	Ч.Мягмаржав		6,143,085	1,544,000	2,212,284	2,386,801	6,143,085	238,680
40	Ц.Зоригмаа	Гурванбулаг	6,143,085	1,544,000	2,212,284	2,386,801	6,143,085	238,680
41	Ш.Ууганцэцэг		6,143,085	1,544,000	2,212,284	2,386,801	6,143,085	238,680
	Гурванбулаг		18,429,255	4,632,000	6,636,852	7,160,403	18,429,255	716,040
НИЙТ			212,525,050	59,052,824	41,925,144	111,547,082	212,525,050	11,154,708

Бүх хүүхэд харагч буюу 41 хүүхэд харагчид 212525 мянган төгрөгийн санхүүжилт ирснээс 111547.9 мянган төгрөгийг цалинд зарцуулж 11154.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар огт төлөөгүй байна.

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

Хүүхдийн “Жаргалант” зуслангийн 2017 оны
үйл ажиллагаа, үр дүн

Бүлэг III

Зуслангийн үйл ажиллагаа 2015 онд зогссон байна.

3.1.Үндсэн хөрөнгөд харуул хамгаалалт байхгүй байна.

Хүүхдийн “Жаргалант” зуслан нь хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хүүхэд бүрийн авъяасыг нээх зорилготой үйл ажиллагаа явуулж нэг хүүхдийг хоногийн 9000 төгрөгөөр амраан үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хүүхдийн “Жаргалант” зусланд аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжил хяналтын газраас дүгнэлт гаргаж 2015 оны 6 дугаарын сарын 10-ны өдрийн 39/150 тоот дүгнэлт “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД13-04-03-ын хүснэгт 1-д заасан модон барилгын үндсэн ашиглалтын хугацаа 10-15 жил байдаг бөгөөд дээрх барилгууд ашиглалтад 35 жил болоход их засвар хийгдээгүй нь барилгын бат

бөх байдалд нөлөөлсөн байна. Барилга байгууламжид хийсэн үзлэгээр бүх байшингуудын насжилт хэтэрч хийцүүд илжирч муудсан, хэв гажилтад орж нурах эрсдэл үүссэн, ялангуяа барилгын суурь хэсгийн модон хийцүүд илжирч муудсан, дээврийн төмөр муудсанаас ихээхэн борооны ус гоождог болсон, аянгын хамгаалалтгүй, цахилгаан угсралт нь ашиглалтад орсноос хойш засвар хийгдээгүй, олон жилийн ашиглалтын явцад болон дээврийн хэсэг чийгний улмаас муудаж гэмтэн гал гарах нөхцөл бүрдсэн байгаа нь “Барилгын тухай хуулийн 9-р зүйлийн 9.1.1 дүгээр заалт “хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлж түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан” -ын шаардлагад нийцэхгүй байгаа тул “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7-р заалтыг баримтлан 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 09 цагаас эхлэн аливаа үйл ажиллагаа явуулахыг зогсоох шаардлагатай гэж дүгнэлээ” -ээр үйл ажиллагааг зогсоосон байна.

Зусланд нийт 117335.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 57 нэр төрлийн 169 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Барилга, байгууламж, орон сууц 19-н нэр төрлийн 24 ширхэг 96630.6 мянган төгрөг
- Авто тээврийн хэрэгсэл 1 ширхэг 13333.3 мянган төгрөг
- Тоног төхөөрөмж 17 нэр төрлийн 18 ширхэг 9426.8 мянган төгрөг
- Тавилга, эд хогшил 14 нэр төрлийн 122 ширхэг 944.8 мянган төгрөг
- Зам гүүрний байгууламж 4-н нэр төрлийн 4 ширхэг 1196.0 мянган төгрөг

Тус үндсэн хөрөнгүүд нь 2015 оноос хойш ашиглалт, хамгаалалт байхгүй хашаа хаалга, цонх эвдэрч хэмхэрсэн, цахилгаан хэрэгсэл, гал тогооны тоног төхөөрөмжүүд гэмтэж шатсан байдалтай байна.

Булган аймаг дахь Төрийн
аудитын газар

ГБХЗХГ-н хүүхэд харах үйлчилгээний 2017
оны санхүүжилт, үр дүн

**Дүгнэлт,
зөвлөмж**

Гүйцэтгэлийн аудитаар хувь хүний орлогын албан татвар төлөөгүй зөрчил илэрлээ.

ДҮГНЭЛТ:

- Хүүхэд харах үйлчилгээ нь хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 1.3-т заасны дагуу Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй,
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 12.1.2-т заасны дагуу санхүүгийн бүртгэл, тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж ажиллаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.3 “Аж ахуйн нэгж, байгууллага энэ

хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно” гэж заасны дагуу анхан шатны баримт бичгийг бүрдүүлээгүй нь санхүүжилтийг хэрхэн яаж зарцуулсан нь тодорхойгүй,

- Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журмын 4.8.3-т эцэг эх, асран хамгаалагч, нь хүүхдийн ирцийн бүртгэлийн дэвтэрт өглөө хүүхдээ хүлээлгэн өгөх, орой хүлээн авах бүрдээ гарын үсэг зуруулаагүй зэрэг зөрчил илэрсэн тул хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журам, хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- Татварын ерөнхий хуулийн 18.1.7-д “хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12.1.1 “эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлогоос татвар төлнө” гэж заасны дагуу авч буй цалингаас хувь хүний орлогын албан татварыг төлөөгүй,
- “Жаргалант” зуслангийн үндсэн хөрөнгөнд тавих хяналт, хадгалалт хамгаалалт байхгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Боловсрол соёл урлагийн газрын дарга Б.Эрдэнэбаатарт:

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 12.1.2-т заасны дагуу санхүүгийн бүртгэл, тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэл хөтлүүлэх, Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журмын 7-д “Төрийн байгууллагын зүгээс Мэргэжлийн хяналтын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн байгууллага, Баг хорооны Засаг дарга нь хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг хангаж байгаа эсэхэд хамтран хяналт тавина” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тул Мэргэжил хяналтын байгууллага, багийн Засаг дарга нараар хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг хангаж байгаа эсэхэд хяналт хийлгэх.

Гэр бүл хүүхэд, залуучуудыг хөгжлийн газрын хүүхэд харах үйлчилгээний хүүхэд харагч нар нь Татварын ерөнхий хуулийн 18.1.7-д “хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, Хувь

хүний орлогын албан татварын тухай хуулийн 12.1.1 “эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлогоос татвар төлнө” гэж заасны дагуу авч буй цалингаас 11154.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар төлөөгүй байгаа тул татварын тухай хуулийн 12.1.1-т заасны дагуу 11154.7 мянган төгрөгийн татварыг хүүхэд харагч нараар төлүүлэх.

Булган аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Т.Баярбатад:

Хүүхдийн “Жаргалант” зуслангийн барилга байгууламжууд нь харж хамгаалах манаач, сахиул байхгүй байгаа нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэж заасныг хэрэгжүүлээгүй тул барилга байгууламжийг харж хамгаалах манаач сахиултай болгох.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан арга хэмжээ авч ажиллан 2018 оны 10 дугаар сарын 1-ний дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТОР /Гэрээт ажилтан/

ГБХЗХГ-ЫН ДАРГА

Х.БАТТУЛГА

Т.БАЯРБАТ

НЯГТЛАН БОДОГЧ

П.БУЛГАН

ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР
/ГЭРЭЭТ АЖИЛТАН/

Х.БАТТУЛГА